



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 42

Номгон

Аймгийн Хөгжимт драмын театрын
дуучид, уран бүтээлчдийг дэмжих тухай

Аймгийн Хөгжимт драмын театрын дуучид, уран бүтээлчдийн талаар хэлэлцээд аймгийн хэмжээнд сум, байгууллагын ой тэмдэглэх одон медаль угаах, ургийн баяр зохион байгуулах, тэмдэглэлт өдрүүдийн үед аймгийн Хөгжимт драмын дуучид уран бүтээлчдийг урьж оролцуулах нь түгээмэл байдаг. Гэвч авьяас чадварын болон хөдөлмөрийн үнэлэмж, харилцан адилгүй, зарим тохиолдолд огт үнэлэгдэхгүй байгааг ТЭМДЭГЛЭЭД Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сум, байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагууд мэргэжлийн байгууллагаас дуучид, уран бүтээлчдийг урьж оролцуулахдаа тэдний хөдөлмөрийн үнэлэмжийг сайжруулах зорилгоор 100.000-аас доошгүй хэмжээний мөнгөн дэмжлэг үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгож, төрийн болон хувийн хэвшлийн, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд зөвлөсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг жил бүрийн 12 дугаар сард танилцуулахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР